

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1999 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Иргэний нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/ 14.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг:**

“1.Иргэний нисэхийн дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хуулиар эрх олгогдсон этгээд нисэхийн аюулгүй байдлын үзлэг шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй бол үзлэг шалгалт хийх эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж, хуулийн этгээдийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэх шалтгаангүйгээр мэдээлээгүй бол агаарын хөлгийн даргыг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Иргэний нисэхийн хамгаалагдсан бүсэд хууль бусаар нэвтэрсэн бол хүнийг нэг зуун нэгжээс нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж;

### **2/ 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Агаарын зайг нисэхэд ашиглах журам зөрчсөн бол агаарын хөлгийн даргыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж;

### **3/ 14.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Агаарын зайн зөрчил үйлдсэн агаарын хөлгийн даргыг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/  
хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.24 дэх заалтын “нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч” гэснийг “иргэний нисэхийн хяналтын байцаагч” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын нисэхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “агаарын хаалгаас” гэснийг “орох, гарах цэгээс” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтын “Иргэний нисэхийн тухай хуулийн 18.2-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 22 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## АГААРЫН ЗАЙГ НИСЭХЭД АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “агаарын хаалгыг” гэснийг “орох, гарах цэгийг” гэж, мөн хэсгийн “Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 8.1.7-д” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “агаарын хаалгаар” гэснийг “орох, гарах цэгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.32-т “Иргэний нисэхийн тухай хуулийн 11.2.2-т заасан гэрчилгээ, зөвшөөрөл олгох;” гэснийг “Иргэний нисэхийн тухай хуулийн 18.2.-т заасан гэрчилгээ, зөвшөөрөл олгох;” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.21-д “Иргэний нисэхийн тухай хуулийн 33.2-т заасан үйлчилгээ” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.22-д “Иргэний нисэхийн тухай хуулийн 19.1.1-т заасан үйлчилгээг дотоодод үзүүлэх” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг